



Хөгжил дэвшлийг
хамтдаа бүтээе!

ХАВТАСНЫ ЗУРАГ:

“Зайсан хилл” цогцолбор дахь
“Дүдү” хүүхдийн музейн
уул уурхайн хэсэгт тоглож буй хүүхдүүд

ЗУРГИЙГ:

“Дүдү” хүүхдийн музей

ТАЛАРХАЛ

Энэхүү Оюу толгойн шинэчилсэн стратегийг компанийн болон хөндлөнгийн оролцогч талуудын үнэтэй санал, зөвлөмж, шүүмж дээр үндэслэн боловсрууллаа.

Оюу толгой, цаашлаад Монгол Улсын ирээдүйг цогцлооход үнэтэй хувь нэмэр оруулах энэхүү чухал үйлсэд сэтгэл зүрхээ харамгүй зориулж, уг шинэчилсэн стратегийг боловсруулахад гар бие оролцсон бүх хүмүүст “Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын багийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

АГУУЛГА

- 01 - 02 | [Түүхэн он жилүүд](#)
- 03 - 04 | [Ирээдүйг хамтдаа бүтээж байна](#)
- 05 - 06 | [Бидний стратеги](#)
- 07 - 08 | [Тэргүүлэх чиглэл](#)
- 09 - 10 | [Хамт олон](#)
- 11 - 12 | [Түншлэл](#)
- 13 - 14 | [Эх дэлхий](#)
- 15 - 16 | [Үр өгөөж](#)
- 17 - 18 | [Ажлын үзүүлэлт](#)
- 19 - 22 | [Хавсралт](#)

ТҮҮХЭН ОН ЖИЛҮҮД

Оюу толгойн түүхийг шаргуу хөдөлмөр, бүтээлч санаа, тууштай байдал, хамгийн гол нь үр дүнтэй хамтын ажиллагаагүйгээр төсөөлөхийн аргагүй билээ.

Бид хамтдаа арваадхан жилийн хугацаанд ил ба гүний уурхай, баяжуулах үйлдвэр, бусад чухал барилга байгууламж, дэд бүтцээс бүрдсэн Оюутолгойн өндөр үр ашигтай бизнесийг Өмнийн говьд хувьцаа эзэмшигч талуудын дэмжлэгтэйгээр, Рио Тинто группийн тэргүүн арга туршлагад тулгуурлан, аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлтэйгээр цогцлоож чадлаа. Оюу толгой нь Монгол Улсын өнөө цагийн түүхэн дэх хамгийн том гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, үндэсний уул уурхайн салбарын тулганы чулуу, нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөдөлгүүр болоод зогсохгүй олон улсад Монгол Улсыг төлөөлөх нэрийн хуудас нь болоод байна.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд нийгэм-эдийн засгийн тогтолцооны томоохон шилжилт явагдсанаар удаан жилийн түүхтэй уламжлалт, хөдөө аж ахуйн зэрэгцээ аж үйлдвэрийн бааз суурь нэмэгдэж, эдийн засаг нь төрөлжиж байна. Энэхүү шилжилтийн дүнд улс орон даяар иргэдийн орлого сайжрах боломж бий болж байна. Монгол Улс үндсэндээ хөндөгдөөгүй гэж хэлж болох ашигт малтмалын арвин их нөөцтэй бөгөөд энэ нь нийгэм-эдийн засгийн шилжилтийг санхүүжүүлэхэд томоохон байр суурь эзэлдэг гадаадын шууд хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр шинэ боломж, бололцоог бий болгож, Монгол Улсыг гэрэлт ирээдүйд хөтөлж байна.

Өнөөдөр Оюу толгойчууд агуу үйл хэргийг бүтээлцэж явна. Хойч үед маань уламжлагдан үлдэж, улс орны эдийн засгийг урт хугацаанд тэтгэх зэсийн иж бүрэн уурхайг цогцлоосноороо бид Монгол орон, монголчуудын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах эрхэм нандин боломжийн эзэд болоод байна. Ийн үзэхүл манай уурхайн зорилго зөвхөн хүдэр олборлож, зэс үйлдвэрлэхээр хязгаарлагдахгүй юм. Бид хавьгүй илүү утга учир, өргөн ач холбогдолтой ажил хийж байгаа улс. Бид хамтдаа аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн, дэлхийд тэргүүлэх, тогтвортой зэсийн бизнесийг цогцлоох замаар Монгол улсын хөгжил цэцэглэлтийн түнш нь байна.

Оюу толгой тун удахгүй дэлхийн зэсийн хамгийн том олборлогчдын нэг болно. Гэхдээ бид хамгийн том байх нь чухал бус, хамгийн том зэрэг өөрчлөлтийг бий болгогч байх ёстойгоо ухамсарлаж байгаа. Монгол Улсын Засгийн газар болон дэлхийн 35 оронд үйл ажиллагаа явуулдаг, уул уурхайн томоохон компани болох Рио Тинто группийн хамтын түншлэлийн дүнд Оюу толгой уурхай бий болсон юм. Анх 2013 онд харилцагчдадаа эхний зэсийн баяжмалаа нийлүүлсэн тэр цагаас хойш манай хамт олон Оюу толгойн хүдрийн биетэд агуулагдах эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэх их үйлсдээ хичээнгүйлэн анхаарч ирлээ.

2022-2023 он бол Оюу толгойн хувьд гүний уурхай төслийн үе шатнаас тогтвортой үйлдвэрлэлийн үе шатанд шилжсэнээр хөгжлийнхөө шинэ шатанд гарсан он жилүүд байлаа. 2022 оны эхээр Оюу толгойн хувьцаа эзэмшигч талууд болох Монгол Улсын Засгийн газар болон Рио Тинто групп нь яриа хэлэлцээний замаар гол гол томоохон асуудлуудаар тохиролцоонд хүрснээр төслийн ирээдүйг баталгаажуулсан юм. 2023 оны 3 дугаар сард бид гүний уурхайн үйл ажиллагааг ёслол төгөлдөр эхлүүлсэн нь Оюу толгой болон Монголын уул уурхайн салбарын хувьд мартагдашгүй, түүхэн өдөр байв. Үүгээр зогсохгүй Оюу толгой уурхайг цогцлооход амьдралынхаа багагүй хугацааг зориулсан Монголын үе үеийн геологичид, уул уурхайн мэргэжилтнүүдийн мөрөөдөл биелсэн өдөр байлаа.

Оюу толгойн үйл ажиллагаа цаашид тэлэн өргөжиж хүлэмжийн хийг бууруулах дэлхий нийтийн үйлсэд онцгой хувь нэмэр оруулах бөгөөд зэс нь салхин цахилгаан станцын сэнснээс өгсүүлээд цахилгаан машин хүртэлх шаардлагатай дэд бүтцэд ашиглагдах гол түүхий эд болох юм.


Манай үйл ажиллагаа хурдацтай, зогсолтгүй хувьсан урагшилсаар байна. Гүний уурхайн төсөл үйл ажиллагааны үе шатанд шилжиж, уурхайн ашиглалтын багтай нэгэн цогц болж байгаатай холбоотойгоор бид “Оюу толгой” ХХК-ийн ТУЗ-ийн удирдлага дор стратегийн үзэл баримтлалаа эргэн нэг харж байна. Энэхүү урт хугацааны, шинэчлэгдсэн стратеги нь Оюу толгойн оролцогч талуудыг нэгдмэл зорилгын доор нэгтгэж, боломжит үр ашгийг бүрэн дүүрэн хүртэх, улмаар нэгэнт хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэх зам мөрийг тэдэнд зааж өгөх нь дамжиггүй.

ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭ

Мандах нараар **“Хамтдаа аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн, дэлхийд тэргүүлэх, тогтвортой зэсийн бизнесийг цогцлоох замаар Монгол улсын хөгжил цэцэглэлтийн найдвартай түнш нь байна”** хэмээх бидний зорилгыг төлөөлүүлээ. Зорилго маань биднийг цаашдын стратегийн шийдвэр сонголтонд чиглүүлэх билээ.

Гэрээр бид оюу толгойг билэгдэн илэрхийлж байна, мөн хувь нийлүүлэгчид, харилцагч талуудын хүлээлтэнд хүрэх бидний хүчин чармайлт, оруулах хувь нэмрийн хүрээг тодорхой илэрхийлнэ. Гэр маань байгальд ээлтэй, гайхалтай дасан зохицсон хийцтэй байдаг нь байгалийн элдэв үзэгдлээс хамгаалж байдаг.

Тоонот гэр нь амьдран суух байрын байр сууц гэдэг талаасаа хувьд ч бүтэц зохион байгуулалтынхаа хувьд ч үеэс үед монголчуудын амьдралын салшгүй нэгэн хэсэг байж ирсэн билээ. Эгэл хийгээд боловсронгуй загварчлалтай монгол гэр мянган дамнан бидний гал голомтыг бадрааж, байгалийн тэнцвэрийг хадгалахын хамт байгалийн элдэв үзэгдлээс монголчуудыг хамгаалж байв. Оюу толгой монгол соёл уламжлалыг эрхэмлэн нандигнадгийн хувьд энэхүү стратегийн баримт бичигтээ гэрийн дүрслэлийг ашигласан билээ. Энгийнээр хэлбэл, бид монгол гэр лугаа адил аливаа бэрхшээл сорилтыг даван гарах яс чанартай, ертөнцийн дэлхийн хувьсал өөрчлөлтөд монгол гэр шиг дасан зохицож, хамт олондоо хоёр дахь гэр нь байхыг эрмэлзэж байгаа юм.



Цэнхэр тэнгэрээр бид “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэх” алсын хараагаа илтгэж буй.

Хур бороогоор тулгарч болох эрсдэл бэрхшээл, мөн ирэх боломжуудыг төлөөлүүлсэн ба бид эдгээрийг оновчтой идэвхтэй удирдсанаар үүрэг амлалтуудаа биелүүлэх юм.

Элсэн манхан нь бидний амжилтууд, баялаг түүхийг илэрхийлнэ. Өнгөрснөөс суралцан сайжирч ирээдүй рүү чиглэнэ.

Зэргэлдээх хот айл, жингийн цуваа нь орон нутгийнхан, худалдан авагчид бусад олон түншүүдийг төлөөлнө. Бид зорилгоо биелүүлэхэд түншүүдийн маань хамтын ажиллагаа салшгүй билээ.

Салхи нь дэлхийн чиг хандлагыг илэрхийлнэ. Өнөөдөр ба Ирээдүй – бид төлөвлөгөөндөө дараах чиг хандлагуудыг харгалзан үзлээ: Тогтвортой байдал ба цаг уурын өөрчлөлт, өөрчлөгдөж буй дэлхийн дэг журам, технологи ба дижиталчлал болон эдийн засаг, улс төрийн тодорхойгүй байдал.

СТРАТЕГИЙН ШИНЭЧЛЭЛ

Монголчууд улирлын аясыг даган бууриа сэлгэн гэрээ барьж, байгальтай шүтэлцэн, сайнтай муутай нь дасан зохицож ирсэн шиг бид стратегиа хянан шинэчилж байна. Ингэснээр Оюу толгой бүрэн хүчинд чадалдаа хүрч дэлхийд 4-т эрэмбэлэгдэх зэсийн уурхай болон улмаар Монголын хөгжил цэцэглэлтэд оруулах хувь нэмрээ энэхүү шинэчилсэн стратегиараа бататгаж байгаа юм.

“Оюу толгой”-н гүйцэтгэх удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөл, мэргэжилтнүүд, гадны төлөөлөл байгууллага, уран бүтээлчид, түншүүд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг дотоод болон гадаад оролцогч талуудтай удаан хэлэлцэж зөвлөлдсөний эцэст стратегиа шинэчлэн боловсрууллаа. Өмнөх стратегийг сайтар дүгнэснээ мөн шингээсэн болно.

Бид стратегиа хувь нийлүүлэгчдийн стратеги, бодлогууд тухайлбал “Рио Тинто”-гийн зорилго, стратеги, Зэсийн группийн зэсийн үйлдвэрлэлийг гурав дахин нэмэгдүүлэх зорилт болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон дунд хугацааны зорилтот “Шинэ сэргэлтийн бодлого”-д нийцүүлэн гаргалаа.

Мөн өөрчлөгдөн буй дэлхий ертөнцийг илэрхийлэх гол дөрвөн хөдөлгөгч хүчин зүйлүүд болох тогтвортой хөгжил ба уур амьсгалын өөрчлөлт, өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн дэг журам, технологи ба дижиталжуулалт, дотоод улс төрийн ба эдийн засгийн тодорхойгүй байдал зэрэгт тулгуурлан болзошгүй аюул болон боломжуудыг үнэлж стратегийг шинэчлэн боловсруулсан болно.

СТРАТЕГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БОЛОН ТЭМҮҮЛЭЛ

Гэрийн тооноор Оюу Толгойн 4 Тэргүүлэх чиглэлүүдээ холбогдох Хэтийн Эрмэлзлэлээ төлөөллээ – Хамт Олон, Хамтын ажиллагаа, Хөрст дэлхий болон Хүртэх өгөөж

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Гэрийн хос багана нь бидэнд цаашдын өсөлтийн амбиц зэргийг тодорхойлж өгдөг манай хоёр хувьцаа эзэмшигчийг илэрхийлнэ.

СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ

Гэрийн унь нь бидний Зорилго, Амжилтын Хэмжүүр болон Зорилтуудаас бүрдсэн Стратегийн Үнэлгээг илэрхийлнэ.

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гэрийн ханаар бид Стратегийн Төлөвлөгөөгөө төлөөлүүлсэн бөгөөд энэ нь бид амлалтуудаа биелүүлэхэд зайлшгүй хэрэгжүүлэх үйлдвэрлэлийн нэгдсэн төлөвлөгөө зэрэг байна.

СОНГОЛТУУД

Авдар нь бидний цаашид Стратегийн Төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэх ирээдүйн олон сонголт болон гол шийдвэрүүдийг илэрхийлнэ.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Тулгатай гал нь бидний Санаа тавих, Зоригтой байх болон Сониуч байх бидний Үнэт Зүйлсийг илтгэнэ.



Хамт олон

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүн бүрийн оролцоо, олон талт байдлыг дэмжих соёлыг төлөвшүүлнэ
- Үе үеийн төлөөлөл бахархалтайгаар мөр зэрэгцэн ажиллах боломж бүрдүүлж, чадварлаг ажилтнуудыг эгнээндээ элсүүлж, тогтвортой ажиллах урам зоригоор тэтгэнэ
- Дэлхийн түвшинд өндрөөр үнэлэгдэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ



Хөрст дэлхий

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилгыг компани даяараа онцгойлон чухалчилж, биелүүлэх арга замыг эрэлхийлнэ
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан, сайжруулна
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт учир болох сөрөг нөлөөллөөс сэргийлж, бууруулна
- Улс орны хэмжээнд усны хангамж, нөөц, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад бизнесийн үйл ажиллагааг чиглүүлнэ

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙХ:

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлэн төлөвшүүлнэ
- Нэгдмэл зорилгын дор оролцогч талууддаа аль болох үр ашигтайгаар үйл ажиллагаагаа эрхэлнэ
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтран ажиллана
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллана



**Хамтын
ажиллагаа**

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно
- Стратегиа оновчтой төлөвлөж, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулах замаар үр ашгийг боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ
- Нэгдмэл, уян хатан бодлоготой, шинийг санаачлагч байж, шинэ техник, технологи ашиглан, тасралтгүй суралцаж хөгждөг тэргүүлэх компани байна
- Эрчим хүчний хангамж зэрэг ханган нийлүүлэлтийн сүлжээний чадамж, тогтвортой байдлыг сайжруулан, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг илүү олон харилцагчдад нийлүүлнэ



**Хүртэх
өгөөж**



Хамт олон

ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОНО

• ХАМТ ОЛОН ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Амжилт хамт олны хүчээр бүтдэг.

Бизнес бол үндсэндээ бүтээгдэхүүн, эсвэл үйлчилгээ гэсэн ойлголт. Харин Оюу толгойн хувьд ажиллах хүчээ онцгойлж үздэг. Компанийн амжилтын хуудас бүр нь манай хамт олны нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлээр бичигддэг. Тэд Оюу Толгойн яндашгүй бахархал.

Манай ажилтнууд компанийнхаа амжилтын гол хөдөлгүүр байсаар ирсэн, цаашид ч тийм байх нь дамжиггүй. Хүн бүрийн оролцоог хангасан, аюул осолгүй, нэгнээ дэмждэг, ажлын орчинг хамтдаа бүрдүүлнэ. Хүн бүр бурууд нүд хурц байж, нэгнээ сонсдог, анхаарал халамж тавьдаг өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг ажиллах орчныг хамтдаа бүрдүүлэх учиртай.

Компанийн хувьд ажилчдынхаа эрүүл саруул, аюулгүй, сэтгэл хангалуун ажиллаж амьдрах таатай нөхцөл онцгой чухал. Ажилтан нэг бүр аюул ослоос ангид байж, ээлжээ дуусгаад гэртээ энх тунх харьдаг байх нөхцөлийг бүрдүүлж ажилладаг. Цаашид ч бид аюулгүй ажиллагааг сайжруулах илүү оновчтой арга замыг тогтмол эрэлхийлнэ. Оюу толгой нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагаагаар тэргүүлж, олон улсын хэмжээнд шинэ жишиг бүрдүүлж байна.

Хамт олныхоо оролцоонд суурилж, тасралтгүй суралцан хөгждөг байгууллага байхын төлөө ямагт хичээнэ.


• БИД ЮУНД ТЭМҮҮЛЖ БАЙГАА ВЭ?

- **АЖИЛЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНД:** Хүний амь нас эрсдэх осол зөрчил, хөдөлмөрийн чадвар бүрмөсөн алдах бэртэл гэмтэл, өвчлөлөөс бүрэн сэргийлж, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн (өмнөх болон ирээдүйн) үзүүлэлтээр салбартаа тэргүүлэгч нь байна.
- **СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ ХАМТ ОЛОН:** Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтийг 80-100-д хүргэнэ
- **ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАНГАСАН ХАМТ ОЛОН:** Урт хугацаандаа ажилтнуудын 50%-ийг эмэгтэй ажилтнуудаар бүрдүүлнэ
- **ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЛТЭЙ АЖИЛЛАХ ОРЧИН:** Ажилтнуудаа сургалтад бүрэн хамруулж, тодорхой асуудлуудыг шийдвэрлэн, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ

“ӨДӨР БҮР ХҮНДЭТГЭЕ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРӨӨР ДАМЖУУЛАН АЖЛЫН БАЙРНЫ СОЁЛЫГ САЙЖРУУЛНА

Ажилтнуудынхаа аюулгүй, тав тухтай ажиллаж, хөдөлмөрлөхөд ямагт нэн тэргүүнд анхаарч ажиллана. Оюу Толгойд хэн ч гадуурхагдахгүй, аюул ослоос ангид, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх боломжтой тийм л ажлын байрыг бүрдүүлэхийг зорьж ажиллана.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд 2022 онд “Өдөр бүр хүндэтгэе” сургалтын хөтөлбөрт 600 орчим удирдах ажилтныг хамруулсан. Энэхүү хөтөлбөр нь удирдах ажилтнуудад баг хамт олондоо аюулгүй орчин бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг ойлгуулах, ёс зүйгүй, үл хүндэтгэсэн зан үйл гарахаас сэргийлэх ур чадварыг нь төлөвшүүлэх зорилготой. 2023 оны нэгдүгээр улирлаас эхлэн уг хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудад зориулсан сургалтыг амжилттай эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт ажиллагсдын 40 хувийг хамруулаад байна. Энэ ахархан хугацаанд ийм гайхалтай амжилттай ажилласан нь бахархууштай. Цаашид уг сургалтад гэрээт компаниудын ажилтнуудыг хамруулснаар нийт ажиллах хүчийг 100 хувь хамруулах зорилт хангагдах юм.



| БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Манай үнэт зүйлс нь байгууллагын соёлын гол цөм бөгөөд уг стратегийг хэрэгжүүлэх бидний ажлын арга барил болно.

АНХААРАЛ ХАЛАМЖТАЙ



Бид хамт олноо эрүүл саруул, аюулгүй байлгахад анхаарч, халамжилдаг. Бие биенээ хүндэтгэсэн, итгэлцэлд суурилсан харилцааг бэхжүүлэн, аливаа үйлдлийнхээнөлөөллийг үргэлж ухамсарладаг. хамт олон, хүрээлэн буй орчин, орон нутгийн иргэдийн сайн сайханд хэвь нэмрээ оруулах боломжийг цаг ямагт эрэлхийлдэг.

ЗОРИМОГ ШИЙДЭМГИЙ



Бид бурууд нүд хурц, ёс зүйтэй байж, шаардлагатай үед шийдэмгий алхам хийж чаддаг. Бид шинийг туршихаас эмээдэггүй. Саад бэрхшээлийг хамтдаа даван туулж, нэгдмэл зорилгоо биелүүлэхийн төлөө тууштай зүтгэнэ.

СОНИУЧ СОРГОГ



Шинэлэг санааг хөхиүлэн дэмжиж, сониуч соргог байж, хамтын хүчээр илүү ихийг бүтээхийг эрмэлздэг. Бид аливааг илүү бүтээлч, аюул осолгүй хийх арга замыг эрэлхийлж, тасралтгүй суралцдаг. Бид хамт олныхоо ололт амжилтаар хөглөгдөж, бусдаас үлгэр дуурайл авдаг.



Хамтын ажиллагаа

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙХ

• ХАМТЫН АЖИЛЛАГАА ЯАГААД ЧУХАЛ ВЭ ?

Бат бэх харилцаа, хамтын ажиллагаатай байхад болж бүтэхгүй зүйл гэж үгүй.

Оюу толгойн хувьд хамгийн том уурхай байх нь чухал бус харин үнэ цэнийг бүтээсэн хамтын ажиллагаагаар хамгийн их эерэг өөрчлөлт авчрах нь чухал юм. Оюу толгой өөрөө Монгол Улсын Засгийн газар, Рио Тинтогийн түншлэлийн илрэл болж, байгуулагдсан цагаасаа хойш нийгэм, байгаль орчны асуудлуудыг компани, хамт олноороо, хотол олон, оролцогч талуудтайгаа хамтран шийдвэрлэж ирсэн билээ.

Итгэлцлийг сэтгэл зүтгэлээр бүтээж, хадгалж явах учиртай. Ил тодыг баримталж бүгдэд өгөөжтэй үр дүнг бий болгох нь бидний хүсэн тэмүүлж буй ирээдүйг бүтээнэ гэдэгт бид итгэж байна. Хамтран ажиллаж гэмээнэ бид амлалтаа биелэл болгож чадна.

Оюутолгой үндэсний болон орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд боловсрол, сургалт, эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэнд, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил зэрэг чиглэлүүдээр дотоодын ба олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж олон олон монголчуудад үр өгөөжөө өгсөн ажлуудыг хэрэгжүүлсээр ирлээ.

Үндэсний, орон нутгийн ханган нийлүүлэгчдийн сүлжээг хөгжүүлэн бэхжүүлэх, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог хөхүүлэн дэмжих нь Оюу толгойн түншлэлийн бодлогын цөм байсаар ирсэн бөгөөд цаашид ч энэ шугамаа баримтлах болно.

Бид бүтээсэн ололт, амжилтаа ахиулах болно.

• БИД ЮУНД ЗОРЬЖ БАЙГАА ВЭ ?

- **УЛС ОРНЫХОО ХАМГИЙН ҮНЭ ЦЭНТЭЙ КОМПАНИ БОЛНО:** Компанийн нэр хүндийн үндэсний индексийг тэргүүлж, улс орноо дэлхийн тавцанд таниулах замаар олон улсад байр сууриа бэхжүүлнэ.
- **ХОЛ ЗАМД ДӨРӨӨ НИЙЛСЭН ИТГЭЛТ ТҮНШ БАЙНА:** Салбарын стандартыг ахиулж, ханган нийлүүлэлтийн сүлжээнд үнэ цэнийг бий болгодог, хариуцлагатай бизнесийг үлгэрлэгч гэдгээрээ оролцогч талууд болон гэрээт түншүүдэд хүлээн зөвшөөрөгдөнө.
- **НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ТҮҮЧЭЭЛЭГЧ БАЙНА:** “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан”- гийн 2026 он хүртэлх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж, дараагийн үе шатыг төлөвлөн, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, үйлдвэрлэлийг төрөлжүүлэх чиглэлд найдвартай түнш нь байна.



ХАНБОГД СУМЫН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР БАЙНА

Сүүлийн 20 жилийн хугацаанд Оюу толгой компани Ханбогд суманд тогтмол хөрөнгө оруулалт хийж ирсэн бөгөөд цаашид ч энэ ажил манай стратегийн гол санаачилгуудын нэг байсаар байх болно. Ханбогдыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө нь тогтвортой хөгжлийг хангах урт хугацааны үндсэн бодлого юм.

2022 оны гуравдугаар сард Оюу толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ханбогд сумыг хөгжүүлэх стратегийг баталж, дараагийн таван жилд Ханбогд суманд 50 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсэн. Энэхүү төлөвлөгөөнд Ханбогд сумын эдийн засагт урт хугацаанд, тогтвортой дэмжлэг үзүүлэх зорилгоор “дэмжлэг үзүүлэгч тал”-аас “хөгжлийн хурдасгуур” нь болох стратегийн шилжилтийг тусгасан.

Улмаар 2022 оны тавдугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд, Өмнөговь аймгийн Засаг дарга, Ханбогд сумын Засаг дарга, Оюу толгой компанийн Гүйцэтгэх захирал нар “Ханбогд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040” хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд цаашид Ханбогдыг гэр бүлд ээлтэй, амгалан тайван хот болгон хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн олон төсөл хэрэгжүүлнэ.



Хөрст дэлхий

БАЙГАЛЬ ОРЧНОО ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

• ЯАГААД ХӨРСТ ДЭЛХИЙ ЧУХАЛ ВЭ?

Хүмүүний цорын ганц өлгий болсон байгаль эхээ эрхэмлэн хамгаалж, хөрст дэлхийд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах чиглэлээр нийгмийн хүлээлт улам бүр нэмэгдсээр байна. Дэлхий нийтээрээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар зорьж буй энэ үед Оюу толгойн хамт олон ч тэргүүлэх зорилтуудаа хувьцаа эзэмшигчдийн хувьд энэ чиглэлд хүлээсэн үүрэг амлалттай уялдуулж байна.

Манай зэсийн үйлдвэрлэл нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, илүү ногоон, тогтвортой хөгжилд хүрэхэд чиглэсэн дэлхий дахины хүчин чармайлтад чухал байр суурь эзэлнэ. Түүнчлэн хөрст дэлхийд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бууруулж, алсын хараатай үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж ажиллана.

Говь нутаг маань онцгойлон анхаарал халамж шаардсан өвөрмөц эмзэг тогтоцтой. Байгаль орчныг хамгаалах нь компанийн стратегийн үндсэн зорилтуудын нэг бөгөөд 2036 он гэхэд биологийн олон янз байдалд цэвэр дүнгээр эерэг нөлөө үзүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ нь манай үйл ажиллагаанаас хөрст дэлхийд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бууруулахын зэрэгцээ хүрээлэн буй орчноо хамгаалахад хувь нэмэр оруулна гэсэн үг юм. Эл зорилгодоо хүрэхийн тулд салбарын мэргэжилтнүүд болон орон нутгийн иргэд, олон нийтийн зөвлөгөө, дэмжлэгийг үндэслэж ажилладаг.

Энэхүү шинэчилсэн стратегийн хүрээнд зөвхөн уурхайн ус ашиглалтаар зогсохгүй устай холбоотой улс орны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд оролцож, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боломжуудыг эрэлхийлнэ. Зэс үйлдвэрлэлийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон усны нөөц Өмнийн говьд хомс учраас усны зүй зохистой ашиглалтад гол анхаарлаа хандуулдаг. Үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахын сацуу орон нутгийн иргэд, тэдний үр хойчид хүрэлцэхүйц усны нөөцтэй байлгахын төлөө ус ашиглалтын хувьд дэлхийн жишгээс бага ус ашиглах горимтой баяжуулах үйлдвэр байгуулсан. Хараат бус судалгааны институт “Скарн Ассошиэйтс”-аас 2022 онд ижил төрлийн 157 уурхайд хийсэн харьцуулсан судалгааны үр дүнд Оюу толгойн уурхай усыг үр ашигтай зарцуулдаг зэсийн уурхайнуудын эхний 25%-д багтаж байгааг баталгаажуулсан. Мөн бид хэрэглэж буй усаа дахин боловсруулж ашиглах талаар ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар усны дахин ашиглалтын түвшин 85%-тай байна.

• БИД ЮУНД ЗОРЬЖ БАЙГАА ВЭ?

- **ХӨРСТ ДЭЛХИЙД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ЗЭСИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ:** 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн зөрүүг тэглэнэ, усны үр өгөөжтэй хэрэглээ, дахин ашиглалтын үзүүлэлтээр салбартаа тэргүүлнэ (цаашдын судалгаанд үндэслэн зорилтыг тодорхойлно).
- **ЗӨВХӨН УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ҮЛ ХЯЗГААРЛАГДАХ ҮЙЛ ХЭРЭГ:** 2032 он гэхэд 100 сая мод дүйцүүлэн тарьж, биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэх зорилтдоо 2036 он гэхэд хүрэх ба улс орны хэмжээнд усны хангамж, нөөц, чанар, аюулгүй байдлыг дэмжих чиглэлд хамтарч ажиллана.
- **ХӨРСТ ДЭЛХИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ҮЛЭМЖ БУУРУУЛНА:** 2030 он гэхэд хог хаягдлын цэг дэхь эрдсийн бус хог хаягдлын хэмжээг 50% бууруулах, уурхайн талбайн гаднах шороон уст давхаргад үзүүлэх нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зэргээр уурхайн үйл ажиллагаанаас үүдэх сөрөг нөлөөллийг бууруулна.



ЭХ ОРНОО ОЙЖУУЛАХЫН ТӨЛӨӨ ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛНА

Оюутолгойчууд жилд хоёр удаа мод тарьдаг уламжлалтай. Энэ үйл хэргээ өргөжүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, зуун сая мод тарих үүрэг хүлээсэн билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд мод тарьж, ургуулахаас гадна ойн аж ахуйн салбарын чадавхыг сайжруулах юм. Өнгөрсөн жил Улаанбаатар, Ханбогд, Даланзадгадад нийт 50 мянга гаруй мод тарьснаас гадна Сэлэнгэ аймгийн Ялбаг хэмээх газарт уурхайн үйл ажиллагаанд нэрвэгдсэн 110 га газрыг нөхөн сэргээв. Нэг зуун сая мод дүйцүүлэн тарих үүргээ 2030 он гэхэд хэрэгжүүлэхийг зорьж байна.



Хүртэх өгөөж

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭНЭ БҮТЭЭНЭ

• ЯАГААД ХҮРТЭХ ӨГӨӨЖ ЧУХАЛ ВЭ?

Түүхий эдийн үнэ болон уул уурхайн салбарын аль аль нь туйлын их хэлбэлзэлтэй бөгөөд тодорхой мөчлөгт нэрвэгдэж байдаг. Эдгээр мөчлөгийн туршид ашигтай ажиллах нь бизнесийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

Түүхий эдийн зах зээлийн ийм хэлбэлзэлтэй нөхцөлд өртөг зардлыг оновчтой болгож, ашиг орлогоо нэмэгдүүлэх нь ирээдүйгээ баталгаажуулахад нэн чухал юм. Урт хугацаанд бизнесийн үйл ажиллагаа явуулах учраас өнөөдрийн шийдвэрийг тэнцвэртэй гаргах замаар маргаашийн Оюу толгойн хүчийг улам чамбайруулж байх шаардлагатай.

Хүдрийн биетийн судалгаа, мэдлэгээ зузаатгахын хэрээр олборлолт, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг улам оновчтой болгон сайжруулахыг зорьдог. Ирэх арван жилд гүний уурхайн үйлдвэрлэлээ жигдрүүлж бүрэн хүчин чадалд нь хүргэж, Оюу толгойн бодит нөөц бололцоог бүрэн нээх болно. 2028-2036 онд үйлдвэрлэлийнхээ оргил үед жилд 500,000 мянган тонн зэс үйлдвэрлэж дэлхийн зэсийн хамгийн том дөрвөн уурхайн нэг болох төлөв харагдаж байна.

Олон жилийн настай нийт хүдрийн биетийн тойм мэдээллийг дараагийн хуудсанд харуулсан болно. Эдгээр хүдрийн биет нь Оюу толгойн өрсөлдөх чадварын давуу талуудын нэг бөгөөд үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал улам бүр нэмэгдэхийн зэрэгцээ цаашид нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлага гарна. Эдгээрийг харгалзан үзвэл эдгээр хүдрийн биетийг блокчлон олборлох болон бусад арга техник ашиглахаас гадна үйл ажиллагаа, хөрөнгийн оновчтой стратегийг хослуулан олборлох нь зах зээлийн олон янзын мөчлөгүүдийн турш ашигтай ажиллах үндэс болох юм.

Компанийн өсөлтийг дэмжих, үйл ажиллагааны төгөлдөршилд хүрэх илүү оновчтой арга замыг ямагт эрэлхийлж ирсэн. Цаашид үйл ажиллагаагаа илүү аюулгүй, ухаалаг болгохын тулд тэргүүний технологи ашиглах нь үр дүнтэй.

• БИД ЮУНД ЗОРЬЖ БАЙГАА ВЭ?

- **ШИЛДЭГ УУРХАЙ БОЛНО:** Зэсийн үйлдвэрлэлийг төлөвлөгөө ёсоор хэрэгжүүлж, боломжтой үед төлөвлөгөөгөө давуулж биелүүлнэ. Тасралтгүй суралцаж, шилдэг технологийг нэвтрүүлэх замаар үр ашгийг цаашид нэмэгдүүлнэ.
- **НӨӨЦ БОЛОМЖОО БҮРЭН АШИГЛАНА:** Нуруулдан уусгах технологи нэвтрүүлэх, Хойд Хюго ордын ашиглалтын 2-р давхар, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл, Оюут гүний уурхайн олборлолтыг эхлүүлэх зэргээр дэвшүүлсэн болон зорьсон хөгжлийн хувилбаруудыг хэрэгжүүлнэ.
- **САНХҮҮГИЙН ӨНДӨР ГҮЙЦЭТГЭЛТЭЙ АЖИЛЛАНА:** Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашгийг нэмэгдүүлж, дунд хугацаанд C1 мөнгөн зардлын үзүүлэлтээрээ тэргүүлэгчдийн эгнээнд эн зэрэгцэхийг зорино.
- **ҮРГЭЛЖ ТҮРҮҮЛЖ АЛХАНА:** 2030 он гэхэд нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 5 хүртэлх хувийг шинэ зах зээлд борлуулна.



ОЮУ ТОЛГОЙН БҮЛЭГ ОРД: МАНЙ ҮР ӨГӨӨЖ ХААНААС ЭХЛЭЛТЭЙ ВЭ?

Оюу толгой нь зэс, алт, мөнгө агуулсан бүлэг ордтой. Тэдгээр нь хойноос урагшаа 12 км сунаж тогтсон Хюго Дамметтын хойд бүс, Хюго Дамметтын өмнөд бүс, Оюут, Херуга ордуудаас бүрддэг.

– ОЮУТ ОРД

2001 онд хийсэн хайгуулын өрөмдлөгийн үр дүнд 508 метр зузаантай, хүдрийн биетийн тонн тутамд дунджаар 0.81 грамм алт, 1.17 хувийн зэс агуулагдсан, зэсээр баялаг сульфидын эрдэсжилтийн бүс илрүүлсэн билээ. 2002 онд дахин өрөмдлөг хийж, тус эрдэсжилтийн бүсийн хэмжээг баталгаажуулж, дөрвөн тусгай хүдрийн биет бүхий бүлэг орд болохыг тогтоосон юм. Өмнөд Оюут орд нь 2.7 км урт, 1.5 км өргөн талбайг хамрах ба одоо тус ордод ил уурхайн аргаар олборлолт явуулж байна.

– ХЮГО ДАММЕТ ОРД

Айвенхоу Майнз Монголиа компани нь Оюу толгойн тусгай зөвшөөрөлтэй талбайн хойд хэсэгт 2002 оны сүүлээр хайгуулын цооног өрөмдөж, кернийн дээжлэлт хийхэд газар доор 222 метр болон түүнээс доош гүнд 638 метр талбайд сунаж тогтсон зэс, алтаар баялаг эрдэсжилт харьцангуй залуу тунамал чулуулагт агуулагдаж байгааг тогтоосон билээ. Үүний дараах өрөмдлөгийн хөтөлбөрөөр тус хүдрийн биет нь гурван километрээс доошгүй талбайд үргэлжилж буйг баталгаажуулсан юм. Ийнхүү эдгээр өрөмдлөгийн ажлаар Оюу толгойн тусгай зөвшөөрлийн талбайн хойд бүсэд бас нэг орд илрүүлсэн ба уг эрдэсжилт, хүдрийн биетийг илрүүлэх ажлыг удирдаж, онцгой үүрэг гүйцэтгэсэн геологичийн нэрээр уг ордыг Хюго Даммет гэж нэрлэсэн юм. Хюго Даммет нь зэс, алтны хамгийн өндөр агуулгатай дэлхийн хамгийн томд тооцогдох ордын нэг юм.

– ХЕРУГА ОРД

Тус компаниас 2007 онд хийсэн цуврал өрөмдлөгийн үр дүнд зэс, алтаар баялаг хүдрийн бас нэгэн шинэ биет, түүний дээр орших молибдены баялаг нөөцтэй хүдэржилтийн бүс илрүүлсэн юм. Тус ордын хамгийн гүн өрөмдсөн цооног 2736 метр хүрсэн. Херуга гэдэг нэрийг Гандантэгчинлэн хийдийн хамба лам Д.Чойжамц уг ордод өгсөн бөгөөд тэр нь Санскрит хэлэнд “дээдийн аз жаргал” гэдэг утгатай аж. Уг ордыг ашиглаж эхлээгүй байна.

I АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Бидний тэмүүлэлтэй уялдсан ажлын үзүүлэлт нь зорилтууд, амжилтын хэмжүүрүүд болон зорилтот үзүүлэлтүүд агуулах бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх цаг хугацаатайгаа байна.



Хамт олон

- Аюулгүй ажиллагааны хувьд олон улсад жишигт нийцэхүйц орчин нөхцөлийг бүрдүүлнэ
- Ажилчдын эрүүл мэнд, тэдний ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг улам сайжруулах соёлыг төлөвшүүлнэ
- Оролцоо, олон янз байдал, хамтын ажиллагааг дэмжих ажлын байрны соёл бүрдүүлнэ
- Үе үеийн төлөөлөл урам зоригтой мөр зэрэгцэн хөдөлмөрлөх ажлын байрны орчин нөхцлийг бүрдүүлнэ
- Дэлхийд өндрөөр үнэлэгдэхүйц ур чадвартай ажилтнуудыг бэлтгэж хөгжүүлнэ



Хамтын ажиллагаа

- Гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаа ил тод, хариуцлагатай хэрэгжүүлнэ
- Оролцогч талуудтай өргөн хүрээнд үр ашигтай хамтарч ажиллах, улс орны хөгжилд хувь нэмэр оруулна
- Олон улсад өрсөлдөхүйц үнэ өртөг бүхий, илүү уян хатан, эдийн засгийн эерэг нөлөөлөл үзүүлэх үндэсний ханган нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг бий болгоно
- Өмнөговь аймаг болон Ханбогд сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, хамтарч ажиллана
- Худалдан авагчидтай нягт харилцаа тогтоож, сэтгэл ханамжийг өндөр түвшинд хадгална



Хөрст дэлхий

- Хүлэмжийн хийн ялгаралыг тэглэнэ
- Биологийн олон янз байдалд цэвэр эерэг нөлөө үзүүлнэ
- Байгаль орчны осол зөрчилгүй ажиллана
- Төслийн талбай орчмын хэрэглэгчдийн усны чанар, хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
- Дэлхийн хэмжээнд усыг хамгийн үр ашигтай хэрэглэдэг зэсийн уурхайн нэг болно
- Монгол Улсын усны хангамж, нөөц, чанар, аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулна
- Хог хаягдлын аюулгүй, тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ
- Уурхайн хаалттай холбоотой сөрөг нөлөөллийг бууруулна




Хүртэх өгөөж

- Гүний уурхайн төслийг хэрэгжүүлж дуусгана
- Уулын ажлын төлөвлөгөөг оновчтой хэрэгжүүлнэ
- Үйл ажиллагаагаа тасралтгүй, нэгдмэл, динамик байдлаар сайжруулна
- Нэмүү өртгийн сүлжээний зардлыг оновчтой болгоно
- Санхүүжилтийн бүтцийг оновчтой болгоно
- Хөрөнгийн хуваарилалтыг оновчтой болгоно
- Хүдрийн биетийн ойлголтыг сайжруулсанаар бид уурхайн үйл явцын үед тохиолдож болохуйц эрдслүүдийг ойлгох мөн шийдвэр гаргахад дэмжлэг болно
- Үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлтийг тасралтгүй хийх замаар цаашдын нөөц боломжийг тодорхойлно
- Үйлдэрлэлийг бүтцийг оновчтой болгож, бүтээгдэхүүийг нэмэгдүүлэхээс гадна нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн судалгаа хийнэ
- Оюу толгойн цахилгаан эрчим хүчний хангамжийг аюулгүй, тогтвортой, тасралтгүй хадгална
- Өндөр үнэ цэн шингэсэн бүтээгдэхүүн санал болгож худалдан авагчийн бааз сууриа төрөлжүүлж сайжруулна
- Өрсөлдөхүйц, уян хатан, тогтвортой ханган нийлүүлэлт, түгээлтийн сүлжээ бий болгоно



ХАВСРАЛТ ОЮУ ТОЛГОЙ ТОВЧХОНООР

Монгол Улсын Өмнөговь аймагт орших Оюу толгойн уурхай бол одоогоор олдоод буй, дэлхийн зэс, алтны хамгийн том ордын нэг. Мөн хамгийн орчин үеийн хийгээд аюулгүй, байгальд ээлтэй уурхайдын нэг юм



600 км



Улаанбаатар

45 км



Оюу толгойн өлгий нутаг болох хамгийн ойрын сум Ханбогд

220 км



Өмнөговь аймгийн төв Даланзадгад

80 км



Гашуун сухайт, Монгол Хятадын хил

Оюу толгойн ил уурхайн үйл ажиллагаа 2011 онд эхэлсэн бол Монголын түүхэн дэх хамгийн том үйлдвэрийн цогцолбор болох баяжуулах үйлдвэр 2013 оноос эхлэн зэсийн баяжмал үйлдвэрлэж эхэлсэн юм. Уурхай өнөөгийн дэд бүтцээрээ хэдэн арван жил ажиллах боломжтой.

“Оюу толгой”-н ТУЗ гүний уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг 2022 оны нэгдүгээр сард гаргасан. Ингэснээр уурхайн хамгийн үнэ цэнтэй нөөцийг ашиглах эхлэл тавигдаж, улмаар 2023 оны эхний улиралд үйлдвэрлэл нь эхэлсэн юм.



“Оюу толгой” бол Монгол Улсын Засгийн газар (34 хувь), “Рио Тинто” групп (66 хувь)-ийн хамтран эзэмшдэг компани. “Рио Тинто” групп хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс компанийн үйл ажиллагааг удирдан явуулдаг



“Оюу толгой”-н төв байр Улаанбаатар хотод байрладаг. Тус оффис дахь багууд бизнесийн үйл ажиллагааг зохион байгуулж, компанийн засаглалыг өндөр түвшинд хэрэгжүүлэн, хөрөнгө оруулагч болон оролцогч талуудын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг бүрэн биелүүлэхэд анхаарч ажилладаг. “Оюу толгой” мөн Даланзадгад, Ханбогдод төлөөлөгчийн газартай.


Үйл ажиллагааны багийнхан уурхайн цогцолборт FIFO буюу нислэгээр ирж очих зарчмаар ажилладаг.



• ИЛ УУРХАЙ

Ил уурхайн олборлолт нь уламжлалт зарчмаар, утгуурт ачигч-өөрөө буулгагч гэсэн хослолоор, өрөмдөх, тэслэх, ачих, тээвэрлэх гэсэн шат дамжлагаар явагддаг. Үйл ажиллагаа нь 24 цагийн турш тасралтгүй явагддаг бөгөөд уурхайчид 12 цагийн ээлжээр ажиллана. Ил уурхай өдөрт 100 мянган тонн хүдэр олборлох зорилтоо давуулан ажиллаж байна.

Тэсэлсэн чулуулгийг аварга экскаватораар утган, Монголдоо хамгийн томд тооцогдох, 320 тоннын даацтай өөрөө буулгагч 30 машинд ачна. Эндээс хоосон чулуулгийг овоолго руу, хүдрийг ил уурхайн харалдаа байх анхдагч бутлуур луу тээвэрлэдэг. Ийнхүү буталсан хүдрийг 2.7 км урттай туузан дамжуургаар тээвэрлэн баяжуулах үйлдвэрийн анхдагч хүдрийн агуулах руу, дараа нь баяжуулах үйлдвэр лүү хүргэнэ.



• БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

Ил уурхайгаас олборлосон хүдэрт багахан хэмжээний эрдэс агуулагддаг. Тодруулбал, ил уурхайгаас олборлосон тонн хүдэр тутамд дунджаар 4 кг орчим зэс, граммыг гурав хуваасны нэгээс ч бага алт агуулагдаж байдаг. Гүний уурхайн үйлдвэрлэл эхэлснээр хүдэр дэх зэс, алтны агуулга нэмэгдэх ч ихээхэн боловсруулалт хийсний дараа л зах зээлийн шаардлага хангахуйц бүтээгдэхүүн болно.

Оюу толгойн Баяжуулах үйлдвэр хүдрийг хаягдал чулуулаг, хольцоос ялган салгах боловсруулалтыг хийдэг. Ийн бэлэн болсон баяжмал ойролцоогоор 22 хувийн зэсийн агуулгатай байдаг бол гүний уурхай ашиглалтад орсноор энэ тоо 30 хүртэл өсөх тооцоололтой. Энэ нь өнөөг хүртэл олборлолтын эх үүсвэр байж ирсэн ил уурхайнхнаас мэдэгдэхүйц өсөн нэмэгдэнэ гэсэн үг.

Уурхайд олборлосон хүдэр бутлуур, тээрмүүдээр дамжин жижгэрээд, баяжуулах боловсруулалтад бэлэн болно. Зарим тээрэм нь дэлхийд томоохонд тооцогдохуйц төхөөрөмжүүд билээ. Тээрэмдсэн хүдрийг хөвүүлэн баяжуулах хэсэг рүү шилжүүлж, зэс, алт, мөнгийг хөөсөнд наалдуулж авна. Энэ шатанд баяжмал өтгөрүүлэгчийн тусламжтайгаар үнэт материал, хаягдлаас шавхаж авсан усаа уурхайн үйл ажиллагаанд дахин ашигладаг. Ингээд өтгөрүүлж хатаагаад нарийн ширхэгтэй нунтаг баяжмал бүтээгдэхүүн бий болгоно. Илүү өндөр агуулгатай хүдэр боловсруулж чадахуйц болгож, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нь нэмэгдүүлэх үүднээс баяжуулах үйлдвэрийг гүний уурхайн бүтээн байгуулалттай зэрэгцүүлэн шинэчилж байна.




• ГҮНИЙ УУРХАЙ

Ил уурхайтай харьцуулахад эрдсийн илүү өндөр агуулгатай гүний бүлэг орд нь Оюу толгойн ашиг орлогын цөм болно. Агуулга сайтай эдгээр ордоо түшиглэн Оюу толгой дэлхийн хамгийн том зэсийн уурхайнуудын нэг болох билээ.


Газрын гадаргаас 700 метрийн гүнд оршдог хүдрийн энэхүү биетүүдийг ил уурхайн хэлбэрээр олборлох боломжгүй. Эдгээр хүдрийн биет газрын гүнд, тархай байрлалтай учир геотехник болон эдийн засгийн үр ашиг талаасаа блокчлох аргаар олборлоход илүү тохиромжтой. Энэ арга нь хүдрийн биетийг өөрийн жингээр нь доош нураан доороос нь бутлан хүдэр буулгуураар цуглуулан авч, туузан дамжуулгаар газрын гадарга дээр гаргадаг арга юм. Газрын гүнд байгаа хүдрийн биетийг олборлоход блокчлох арга нь хамгийн зардал багатай, үр дүнтэй.

Хүдрийг суллаж нураах үйл явц нарийн төлөвлөгөөний дагуу, чанд хяналт дор явагдана. Рио Тинто групп блокчлон олборлох аргыг хэрэгжүүлдгээрээ дэлхийд танигдсан, энэхүү аргаар мэргэшсэн цөөн хэдэн компанийн нэг. Тус группийн Гүний уурхайн технологийн төвд дэлхийн шилдэг мэргэжилтнүүд ажиллаж, гүний уурхайг загварчлах, бүтээн байгуулах, олборлоход хамгийн тохиромжтой арга барилыг судалж боловсруулдаг. Блокчлон олборлох аргаар олборлоход үйл ажиллагааны зардал өөр зарим аргаар олборлохоос даруй арав дахин хямд тусна. Үйл ажиллагааны зардал бага байдаг ч эхлээд харьцангуй өндөр зардлыг дэд бүтэц, барилгажилттай холбоотойгоор зарцуулах болдог нь энэ аргын сул тал байдаг. Блокчлон олборлох аргыг аюулгүй, үр дүнтэй ашиглахын тулд үйлдвэрлэл эхлүүлэхээс өмнө нэмэлт дэд бүтцийг бий болгох шаардлагатай. Босоо амыг барихаас гадна, нураах үйл явц эхлэхээс өмнө хүдрийн биетийн доогуур олон километр урт хоолой, ханын бэхэлгээ бүтэц зэргийг байгуулсан байх учиртай.



• НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЛОГИСТИК, ЗАХИАЛАГЧИД БА МАРКЕТИНГ

Оюу толгойн олон улсын зах зээлд нийлүүлсэн зэсийн баяжмалыг цахилгаан машин, компьютер, агаар цэвэршүүлэгч, ухаалаг утас гэх мэт төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж байна. Рио Тинто нь олон улсын туршлагаа ашиглан Оюу толгойд маркетингийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд энэ хүрээнд шууд захиалгаар болон урт хугацаагаар гэрээлэн хийх борлуулалт, логистик, төлөвлөлт, борлуулалтын удирдлагыг хариуцан ажилладаг. Борлуулах үнэ нь дэлхийн зах зээлийн үнээр тодорхойлогдох бөгөөд хайлуулах үйлдвэрт хүргэх тээвэрлэлтийн зардал зэрэг хүчин зүйлс нөлөөлнө.



БАЯЖМАЛ УУТЛАХ
ҮЙЛДВЭР ДЭЭР
ДЭЭЖ АВАХ




АЧИХ



ГААЛИЙН
БҮРДҮҮЛЭЛТ
ХИЙХ



ЗАХИАЛАГЧИД
ШИЛЖҮҮЛЭХ



Хөгжил дэвшлийг
хамтдаа бүтээе.



 /otmongolia
 /otmongolia
 /otmongolia
 /otmongolia
 /oyutolgoi
 www.ot.mn